



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/242

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн 2019 оны төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИМРАМЖЛАХ нь:

1."Огторгуйн асар нийтийн мэдээллийн төв" НҮТББ буюу Ховд телевиз Юнивишн ХХК-тай телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулж иргэд, хэрэглэгчдэд хүргэхээр байгуулсан гэрээг үндэслэн "Телевизийн нэвтрүүлэг дамжуулсны төлбөр"-т дэмжлэг болгох 3 000 000 төгрөг /Гурван сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ"-ний 3.5 дахь заалтад тусгасан Орон нутгийн телевизийг дахин дамжуулах сүлжээнд холбох зардлаас гаргасугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг тухайн байгууллага компани хоорондын хамтын гэрээг үндэслэн тооцон шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн телевизийн нэвтрүүлгийн дахин дамжуулалт, үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн ажилтан /Х.Алтантуяа/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ